

**НЭРТ ЭРДЭМТЭН Ё.ЖАНЧИВЫН
ХЭЛ ШИНЖЛЭЛИЙН ЗАРИМ БҮТЭЭЛИЙН ТАЛААР ТОВЧ ӨГҮҮЛЭХ НЬ**

(Мэндэлсний 50 насны ойд)

А.Пүрэвжанцан

Түлхүүр үг: *Багш, судлаач, эрдэмтэн, хэл шинжээч, бүтээн туурвигч*

Авьяаслаг эрдэмтэн, хэл шинжээч Ёндонжамцын Жанчив 1970 онд Завхан аймгийн Отгон сумын нутаг “Их шарилын өвөлжөө” хэмээх газар төржээ. Тэр бээр 1991 онд МУИС-ийн МСХ-г Монгол хэл, утга зохиолын багш мэргэжлээр төгсжээ. 2000 онд “Дөрвөлжин үсгийн монгол дурсгалын хэлний судалгаа” сэдвээр Хэл бичгийн ухаанаар боловсролын доктор (Ph.D) зэрэг хамгаалсан байна. 1991-2010 он хүртэл МУИС-ийн ХБФ, МСХ, МСС, МСС, МСДС, МХСС, ГХСС-д багшилж байсан. Монголын нууц товчоон, монгол хэлний түүхэн хэлзүй, дундад үеийн монгол хэл, дөрвөлжин үсэг болон монголчуудын үсэг бичиг судлалын чиглэлээр голлон судалдаг байлаа.



*Баруун гараас Ё.Жанчив, А.Пүрэвжанцан. 2008 он
(А.Пүрэвжанцаны хувийн цомог)*

Завхан аймгийн Отгон сумын найман жилийн дунд сургуулийн VII ангийн сурагч Ё.Жанчив академич Ш.Лувсанвандан гуайд захидал бичихдээ өөрийн уншсан, сонирхсон хэл шинжлэлийн олон номыг дурдан мэдүүлээд тань шиг хэл шинжээч, эрдэмтэн болох хүсэлтэй тухайгаа бичсэн байдаг. Аугаа их эрдэмтэн холын хүсэл мөрөөдөлтэй бяцхан хүүг магтан сайшаагаад юуны өмнө 10 жилийн сургуулиа сайн дүүргээд хүрээд ир гэж урам сэргээсэн хариу захидал ирүүлсэн билээ гэж сэтгэлийн баясал үзүүлэн хуучилж суусан нь саяхан.

Мань хүн яасныг бүү мэд, анх их сургуулийн хуулийн ангийн томилолтой ирж, тэр үеийн ректор, академич Н.Содном гуай дээр орж зорилго хүслээ илэрхийлж, Лу багшийнхаа захиа сургаалыг ч үзүүлсээр хуваариа монгол хэлний ангиар солиулснаа “Сайн хүний нэрийг гурав худалдана гэгч болсон доо” хэмээн дурсаж байсан юм. Ингэж явсаар намрын ажлаас хоцорч, солиулсан томилолтоо барьсаар МХУЗФ-ын декан Ц.Сүхбаатар багш дээр иртэл “залыг этгээд, хогийн шаар” гэх жижүүрийн үгээр нь бөмбөгдүүлсээр шууд түүний босоо удирдлага дор 2-р байрны 3 давхрын коридор цэвэрлэх, ангийн цонх шил арчих, ширээ сандал зөөх, ийш тийш зарлага дуудлагад гүйсээр бид хоёр нэгэн намрын үдэхдээ бас ч зан зангаа мэдэлцсэн хэмээн ярьдаг.

Ийнхүү хүсэн хүлээсэн ирээдүйн мэргэжлийнхээ алтан шавыг хатгаж, ачит багш нарынхаа эрдмийн авшгийг хүртэн, сайн сурахын үлгэр жишээг үзүүлсээр 3-р курсийн оюутан ахуйдаа үеийнхээ нөхдөдөө С.Мөөмөө багшийнхаа удирдлага дор “Орчин цагийн монгол хэлний үгийн утга зүй” гэх хичээлийг зааж эхэлжээ.

Ё.Жанчив хүний хорвоод ирээд дөнгөж дөчхөн насалж, МУИС-ийн багш гэж хориодхон жил ажиллахдаа нэг сэдэвт зохиол 1, сурах бичиг ном 4, хамтын бүтээл 4, эрдэм шинжилгээний өгүүлэл 31, сурталчилгааны өгүүлэл 5, ном бүтээлийн шүүмж 2, эрдэм шинжилгээний гадаад, дотоодод тавьсан илтгэл 16, хянан тохиолдуулсан бүтээл 3, эмхэтгэсэн ном, товхимол, өгүүлэл 2, удирдсан эрдэм шинжилгээний ажил 12 (бакалаврын дипломын ажил 7, магистрын дипломын ажил 5), эрдэм шинжилгээний шүүмж, тодорхойлолт 19 (магистрын дипломын ажлын шүүмж 14, шинжлэх ухааны доктор (Sc.D)-ын зэрэг горилсон зохиолын шүүмж 5)-ыг бичжээ. Түүний өөрийнх нь хэлдгээр ёстой “агуу”.

Тэрээр хүмүүний эрдмийг бахдаж, магтаж “агуу” гэх үгийг хэлэхдээ их цөөхөн. Миний сонссоноор гадаадынхаас ганцхан агуу Николай Николаевич Поппе, дотоодынхоос агуу Бямбын Ринчен, агуу Шадавын Лувсанвандан, агуу Домийн Төмөртоогоо, агуу Лхамсүрэнгийн Хүрэлбаатар хэмээн овогтой нь дурдаж, гарын 5 хуруунд багтах энэ хэдийн нэрийг хэлээд л дуусна. Өөр хэн гэж цаашлуулан өдөхүйд миний бодлоор ингээд болоо гэх.

Тухайн үед хэлбичгийн ухаанаар эрдмийн зэрэг хамгаалуулах зөвлөлийн эрхэм гишүүн, тулхтай буурал нэгэн бээр (нэрийг бичихээс түдгэлзэв) “Жанчивын хамгаалалтын ажлыг магтаж сайшаасан нь маш их. Олон гишүүн шууд шинжлэх ухааны доктор өгсөн ч болно гэв ээ. Болоогүй ээ, бас энэ нөхрийн хувийн сахилгыг ч харгалзах ёстой гэсэн нь ч бий. Хувийн сахилга гэдэгт “бор дарс”-ны асуудал багтаж байгаа юм. Чамд ч бас хамаатай” гээд мушийж байж билээ.

Дундад үеийн монгол хэлний судалгаа, дөрвөлжин бичгийн дурсгал дахь түүнийг судалж, туурвисан эрдэм шинжилгээний өгүүллүүдээс хоёр нэгхэнийг сэргээн харваас:

1. “Монголын нууц товчооны нэгэн хэллэгийн учир” (Жанчив Б. 1997:160)

“Монгол улсын түүхч эрдэмтдийн бүтээл дотор “урт дурын хүн” хэмээх нэгэн хэллэг тохиолддог билээ хэмээгээд зөвхөн энэ ганцхан өгүүллийг бичихдээ Д.Нацагдорж, Д.Гонгор, Ч.Далай, Ж.Гэрэлбадрах, Н.Н.Поппе, Д.Цэрэнсодном, Ц.Дамдинсүрэн, Ф.В.Кливез, Сэцэнцогт, Б.И.Панкратов, П.И.Капаров, П.Поуха, С.Калужински, Захчидсэцэн, Хуацай Дугаржав, Т.Мансаан, Элдэндэй-Ардаажав, Их Мянгадай Иринчин, Кү.Дорба, Ш.Озава,

Ш.Гаадамба, П.А.Дарваев, Г.Г. Чимитов, С.А.Козин, Ч.Р.Намжилов, М.Д. Евен, Р.Поп, А.Темир, М.Ууганбаяр, Өргөнгоо Онон, Л.Лигети, И.де Рахевильц, Ю-Вонь-Су, Ш.Чоймаа, Д.Пүрэвдорж, Н.Доржготов, З.Эрэндоо, Б.Напилаас эхлээд өөрийгөө хүртэл 5 тивийн энгийнээс эгэлгүй 40 эрдэмтдийн тодорхойлолтыг харьцуулан жишиж, харгуулан шинжилж, тайлбарлан таниулж, магадлан шүүснээс гадна МНТ, бусад сонгомол эх, англи, герман, чех, орос, хятад, солонгос, япон, халимаг, буриад хэл дээр гарсан олон өгүүлэл эшлэлийг сурвалжлан судалсан нь эрдэмтэн хүний нөр их хөдөлмөр гэдэг нь батлагдах үнэхээр үнэ цэнтэй судалгааг туурвисан байдаг юм.

Ингээд энэ хэллэгийн талаар өөрийнхөө дүгнэлтэд “дыгь~ dygi” гэдэг нь “эгэл, жирийн, доорд, сул, чөлөөтэй” гэсэн утгатай үг болох нь эргэлзээгүй болов уу. Иймээс “Монголын Нууц Товчоон”-ы 191-р зүйл дэх “... minqad-un ja’ud-un noyad кц’ьд-и де’ь-нер-и ьт дыгь-yin гь’ь-ь кц’ьд-и де’ь-нер-и ого’улугун ” хэмээх хэсгийг “мянгадын зуудын ноёдын хөвүүдийг, дүү нэрийг мөн түүнчлэн жирийн хүний хөвүүдийг, дүү нэрийг оруулруун ...” хэмээж буулгавал тохирох мэт санагдана.

Эцэст нь дүгнэвэл, “Монголын нууц товчоон”-ы 191-р зүйлд ганцхан тохиолдох “ьт” хэмээх нь “мөн, түүнчлэн, тэрчлэн, зөвхөн” гэх мэт утга бүхий туслах үг, 191, 224-р зүйлд дөрвөн удаа тохиолдох “дыгь - yin~ dygi-yin” хэмээх нь эгэл, жирийн, сул, доорд, үтэл гэсэн утгатай үг гэсэн санааг дэвшүүлж байна хэмээсэн буй.

2. “Монголын дөрвөлжин үсгийн судлалд профессор Н.Н.Поппегийн оруулсан хувь нэмэр” (Жанчив Б. 2002:123) (Н.Н.Поппе “Квадратная письменность” ном хэвлэгдсэний 60 жилийн ойд) “Профессор Н.Н.Поппе (1897-1991) бол монгол судлал, түрэг судлал, манж-хамниган судлал, харьцуулсан алтай судлал зэрэг өргөн хүрээг хамарсан эрдэм шинжилгээний 500 орчим бүтээл туурвисан дэлхийн монгол судлалын суу билигт эрдэмтийн нэг юм гээд 1944 онд герман хэлээр хэвлүүлсэн “Монголын дөрвөлжин үсэг ба Монголын нууц товчооны хэл” хэмээх бүтээлийг онцолж англи хэлээрх бичвэрийг ишилсэн нь бий. Тухайлбал:

“... As to works which I regard as more important than some other writing of mine, I would choose my books on Mongolian monuments in hP’ags-pa script and on the Mongolian dictionary Muqaddimat al-Adab and the article on the Mongolian material in a Leiden manuscript. These three works contain materials which will always be needed and used” (Бид онцлов Ё.Ж).

Тэрээр дөрвөлжин үсэг, түүний дурсгалын судлалаар 1940 он хүртэл хийсэн судлаачдын бүтээлийн ололт амжилтыг нэгтгэн дүгнэж, тэдний алдаа эндэгдлийг засан залруулж, дөрвөлжин үсгийн дурсгалын хэлний онцлогийг нарийвчлан судалж тухайн үед судлагдаад байсан бараг бүх дурсгалыг хэл бичгийн ухааны үүднээс гүн гүнзгий бөгөөд үлгэр жишээчээр задлан шинжилснээр монголын дөрвөлжин үсгийн судлалд шинэ эрин үеийг нээсэн агаад түүний энэ бүтээл одоо ч үнэ цэнтэй хэвээр байна” гэж хэлэх бүрдээ “агуу” хэмээн уулга алдан шүтэн бишрэгч, эчнээх номын садан их эрдэмтнээ бахархан дүгнэжээ.

3. “Монгол улсад дөрвөлжин бичгийг судалж байгаа нь” МУИС, МСДС, ЭШБ №13 (135) УБ., 1998 өгүүлэлдээ: “1269 онд Хубилай хааны зарлигаар Төвөдийн Пагва лам Лодойжалцаны зохиосон монголын дөрвөлжин үсгээр бичсэн дурсгал бидний үед цөөвтөр уламжлан ирсэн ч түүнийг судлах ажил одоогоос 400-аад жилийн эхэлсэн. Энэ завсар дэлхийн олон хэлээр арвин баялаг ном, өгүүлэл гарсан бөгөөд одоо ч гарсаар байна. Дөрвөлжин үсгийг ЗХУ (хуучин нэрээр), Унгар, Польш, Герман, Англи, АНУ, Итали, Франц, Хятад, Австрали, Япон, Энэтхэг зэрэг олон орны эрдэмтэд нягтлан судалсаар ирсэн. Эдний дотроос Н.Поппе, М.Левицки, Э.Шаванн, Г.И.Рамстедт, П.Аалто, Д.Банзаров, Э.Хениш, Л.Лигети, М.Накано, Ш.Хаттори, П.Пеллио, Зуунаст зэрэг эрдэмтдийг зүй ёсоор дурдах ёстой.

Монголын эрдэмтдээс Ш.Лувсанвандан, Д.Төмөртоогоо, Ц.Шагдарсүрэн, Н.Сэр-Оджав, Ч.Далай нарын олон эрдэмтдийн өгүүлэл бүрийг задлан шинжилж, үнэлэлт өгсөн байдаг.

Мөн манай судлаачид дөрвөлжин бичгийн талаар томоохон хэмжээний ганц сэдэвт зохиол бараг бичээгүй боловч ямар нэгэн асуудлыг сонгон авч шийдвэрлэсэн цөөн бус тооны чамбай өгүүлэл хэвлүүлжээ. Эдгээртээ голдуу гадаадын судлаачдын хөндөөгүй юм уу бага анхаарсан зүйлийг судлан шинжилсэн явдал дөрвөлжин үсгийн судлалд монголын эрдэмтдийн оруулсан томоохон хувь нэмэр гэж онцлон дүгнэжээ.”

Мөн тэрээр хамгийн сүүлд дөрвөлжин үсгийн бусад (хятад, төвд, түрэг гм.) гадаад хэлээрх дурсгалын тухайт нэгэн сэдэвт бүтээлээ туурвин, гар бичмэлээ бараг дуусган үлдээсэн байна.

Ё.Жанчив 2010 оны хаврын тэр гунигт саарал, зэгэл өдөр ид залуу ихийг бүтээж туурвих дөч шүргэх насандаа аав ээж, ахан дүүс, ачит багш, анд нөхөр, номын олон саднаа үүрд орхин мөнх тэнгэрийн оронд дэвшин заларсан юм.

Бага залуу наснаас хэл шинжлэлийн онол арга зүй хийгээд монгол судлалын тогтолцоотой мэдлэгийг шамдан суралцаж, монгол хэл бичгийн түүхэн сурвалжуудын талаар туурвисан шилдэг бүтээлүүд нь эрдэмтэн судлаачдын ширээний ном болсон төдийгүй монгол судлалын үнэт сан хөмөргөд мөнхрөн үлдэх нь дамжиггүй.

Resume

From an early age, he studied linguistic theory and methodology and the system of Mongol studies, and his best works on the historical sources of the Mongolian language became a table book for scholars and will undoubtedly be immortalized in the treasures of Mongol studies.

Номзүй

- Жанчив Ё.** 2010. *Дундад үеийн монгол хэлний судлал*. Эрдэм шинжилгээний бүтээлийн эмхэтгэл. Эмхэтгэсэн Л.Батбилэг. Уб.,
- Жанчив Ё.** 1997. *Монголын нууц товчооны нэгэн хэллэгийн учир*. МУИС. МХС. ЭШБ №8 (116) Уб.,
- Жанчив Ё.** 2002. *Монголын дөрвөлжин үсгийн судлалд профессор Н.Н.Поппегийн оруулсан хувь нэмэр*. Монгол хэл шинжлэл. т.VII (XXIX) f.1-11 Уб.,
- Жанчив Ё.** 1998. *Монгол улсад дөрвөлжин бичгийг судалж байгаа нь*. МУИС. МСДС. ЭШБ № 13 (139) Уб.,
- Поппе Н.** 1941. *Квадратная письменность*. М-Л.,
- Поппе Н.** 1941. *Золотоордынская рукопись на бересте*. М-Л., С.5. 46-50, 57
- Rorpe N.** 1971. Antoine Mostaert, C.I.C.M. Aug. 10, 1881- June 2, 1971 Central Asiatic Journal, XV:38, 164-169
- Rorpe N.** 1957. The Mongolian Monuments in hPags-pa Script (=Gotinger asiatische Forschungen. B.8) Wiesbaden, Translated and edited by J.P.Kruger.